



ЗӨГИЙН АЖ АХУЙ ЭРХЛЭГЧДИЙН ХҮРЭЭНД ЦАХИМ СУДАЛГАА ХЭРЭГЖҮҮЛЖ БАЙНА

Төслийн багаас цахим судалгаа хэрэгжүүлж Монголын ЗАА-д ашиглаж буй зарим технологийн бодит нөхцөл байдал, тулгамдсан асуудлыг шийдэх арга замыг тодорхойлох зорилго тавин ажиллаж байна. Одоо бүл салгах технологийн тухай 3 дахь удаагийн санал асуулга явагдаж байгаа болно. Зөгийчид та бүхэн төслийн фэйсбүүк хуудсанд хандаж маш хялбар байдлаар цахим судалгаандаа оролцох боломжтой тул хамтран ажиллахыг хүсэж байна.


Хоёр дахь удаагийн судалгаа нь Варроа хачгийн улмаас үүсэх эрсдэлд өртөж буй байдалд дүгнэлт хийхэд чиглэсэн ба үүнд нийт 32 зөгийчин оролцов. Судалгааны дүнгээс харахад ирүүлсэн хариултын 90 орчим хувь нь варроа хачгийн улмаас эрсдэлд өртдөг гэсэн байна. Мөн 50 орчим хувь нь тус хачигтай эмийн аргаар, 25 хувь нь эмийн бус аргаар тэмцдэг байна. Хачигтай тэмцэхэд эмийн зохистой хэрэглээ маш чухал байхын зэрэгцээ бал хураалтын улиралд эмийн бус арга ашиглах нь үр дүнтэй байдаг.

Хачигтай тэмцэх зорилгоор туршилт судалгаа хэрэгжүүлж байна

Тус төслөөс өмнөх хэсэгт дурьдсан “хачгийн занга ашиглах” технологийг Монгол орны нөхцөлд үр дүнтэй нэвтрүүлэхийн тулд туршилт судалгааны ажлыг хэрэгжүүлж байна. Энэ арга нь эр үрвэлдэйд халдварласан хачгийг сархиагын хамт ээлж дараагаар авч устгах арга юм.

Туршилт судалгаанд оролцож буй буй зөгийчид, малын эмч нар хамтран хачгийн занга бүхий дээжийг цуглуулан тэнд орсон хачгийг тоолж байна. Энэхүү туршилт судалгааг Мал эмнэлгийн хүрээлэн, Дархан-Уул, Сэлэнгэ аймгийн мал эмнэлгийн газрууд, зөгийчидтэй хамтран хийж буй бөгөөд үр дүнтэй технологи боловсруулж улмаар түгээн дэлгэрүүлэхийг зорьж байна.

Варроа хачгийн улмаас эрсдэл өртдөг үү?




■ 1.Тийм ■ 2. Үгүй

Иймд төслийн багаас хачиг нь эр зөгий бойжиж буй ташаалавчинд орж үрждэг байдлыг ашиглан “Хачгийн занга ашиглах” аргыг нэвтрүүлж буй бөгөөд Монгол оронд илүү үр дүнтэй ашиглах боломжийг судлах зорилгоор туршилт судалгааны ажил хэрэгжүүлж байна. (Доор бичсэн хэсгийг үзнэ үү)

Хэрэв уншигч та хачгийн занга ашиглах аргын тухай болон судалгааны дэлгэрэнгүй дүнтэй танилцахыг хүсвэл төслийн фэйсбүүк хуудсанд нийтэлсэн материалуудыг үзээрэй.



Хачгийн занганы жааз (Зүүн тал) Эр зөгий бойжиж буй сархиаг (Баруун тал)



Эр зөгийн авгалдайд халдварласан хачиг (Зүүн тал) Хачиг тоолж буй малын эмч (Баруун тал)

8-Р САРЫН 3 「ЗӨГИЙН БАЛНЫ ӨДӨР」

Японд 8 гэж хэлэхэд “зөгий”, 3 гэж хэлэхэд “бал” гэж хэлэхтэй адил дуудлагатай байдаг учир 8 дугаар сарын 3-ны өдрийг “зөгийн балны өдөр болгосон байна.

З өгийн б а л нь х үн сний б үтээгдэхүүн тул стандартад нийцсэн байх шаардлагатай байдаг. Монгол улсын үндэсний стандартаар зөгийн баланд дараах үндсэн шаардлага тавигддаг. (MNS 6294:2019)

- Сахарын агууламж 80%-иас дээш
- Чийгшил 20%-иас доош
- Сахароз 5%-иас доош
- Исэлтгүй
- Гадны биетээр бохирдоогүй байх

Зөгийн балыг зөгий, цэцэг хоёр хамтран үйлдвэрлэдэг тул цэцэг бүрээс гаралтай зөгийн бал өөр өөр байдаг. Зөгийн балнаас өөр өөр бэлчээрийн төрөл бүрийн гайхалтай өнгө, үнэр, амтыг мэдэргээе.



© L.S. Miyamoto Project



Монгол орны зарим балт ургамал. Зүүн гар талаас булцуут туйпланцар, цайны хөвөн оройт, мангир, ганга, рапс, үрэл

Төслийн Facebook :

www.facebook.com/BeeDep-MONGOL-2-107843977265085/?modal=admin_todo_tour

Онлайн семинарыг хүргэж байна !

